

БАРГА, БУРИАДЧУУДЫН ТӨРӨЛ САДНЫ ДУУДЛАГЫН ОЛОН ЯНЗАТ ШИНЖ ТЭДГЭЭРИЙН ХАРИЛЦААНЫ НЭВТРЭЛЦЭЛ

Сэцэн, профессор, Хувьт, магистр ӨМИС

Abstract: In modern Mongolian studies, Barag Buriyat accents are regarded as a dialect to be studied, therefore, people think that Barag Buriyat accents are the same dialects. However, according to our deep observation towards Barag Buriyat people's life and interpersonal communication, there are many differences in Barag Buriyat people's language, culture and address form. Therefore, to study the diversity of the Barag Buriyat people's kinship address form and its inconvenience in communication and solving methods by using cross-cultural communication theory which aims to research people who are in different cultures. This is not only important in the Barag Buriyat people's cultural communication, but also plays an important role to keep the local variant of diversified development of Mongolia culture.

In this paper, first of all, based on Barag Buriyat dialect materials in Hulunbuir city, Inner Mongolia, the author summed up Barag Buriyat kinship address form from the aspects of pronunciation, semantic application, vocabulary differences, application environment, meaning transformation, ambiguity of syllable difference and gender staggered. Then, in order to improve the Barag Buriyat communicational obstacles which are caused by the diversity of kinship address form, the author suggested to develop school education, to hold theatrical entertainment and to spread a large-scale of Barag Buriyat's culture, history and related symposium.

Түлхүүр үг: барга буриад, соёл, төрөл садны дуудлага, олон янзат шинж, нэвтрэлцүүлэх арга

Удиртгал

Ямар нэгэн хэл аялгууны судалгааг харилцан нэвтрэлцэлийн талаас үзвэл, тэр хэлний соёлын асуудал төдийгүй тухайн соёлын ойлголтыг илэрхийлдэг гэж болно. Орчин цагийн монгол хэлний судалгаанд барга, буриад аялгууг нэг л нутгийн аялгуунд хамааруулан судалж байгаа тул энгийн хүмүүс барга, буриад аялгуу ижил хэмээн төөрөлдөн ойлгодог байна. Гэвч барга, буриадуудын бодит амьдрал дахь харилцааны асуудлыг нарийвчлан судлавал дуудлага нэрийг багтаасан хэл, соёл нь хоорондоо зөрөөтэй зүйл олон байдаг. Иймээс өөр өөр соёл бүхий хүмүүсийн харилцаа нэвтрэлцэлээр судлагдахуунаа болгосон адил бус соёлтны онолоор барга, буриадчуудын төрөл садны дуудлагын зөрөөтэй байдлыг судлах барга, буриадчуудын хоорондох соёлын харилцан хамаарал төдийгүй орон нутаг дахь хувилбарыг судлан хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

1. Барга, буриадчуудын төрөл садны дуудлага нэрийн зөрөө

Энд барга, буриадчуудын төрөл садны дуудлага нэршил нэн олон янзаар хэрэглэгдэх төдийгүй авианы, утгын, үгсийн сангийн, хэрэглээний орчны гэх мэт зарим шилжсэн утгаар хэрэглэгдэх, үе зэргийн дээд, доодын ялгалын балархайшил,

хүйс солбицон хэрэглэгдэх дуудлага зэрэг долоон асуддлын талаар тодруулна.

Нэг. Авиан зөрөөтэй ч утга хэрэглэлтээрээ адилавар дуудлага

1. Монгол бичгийн хэлний “аав” гэх дуудлагыг шинэ баргын Өвөрбулаг сумаас бусад шинэ барга, зүүн баруун хошууны баргачууд бүр [ɑ:w] гэж авиална. Иймээс шинэ барга зүүн хошуунд биеийг төрүүлсэн бус эр хүйстэн - өөрийн эцэг биш хүн тухайлбал, Авга буюу аавын насны төрөл бус хүмүүсийг “аав” гэж дуудахыг цээрлэнэ. Харин заавал “айлын аав” буюу “хэн хэний ааваа” гэж дуудна. Энэ нь өөрийн төрсөн, тэтгэсэн эр хүйстнээс өөр хүнийг аавтай үл адилтгах санаа буюу (Норжин, Чойдандар, 1992).

Жишээ нь: Жалбуу гэгч манай сайн танил, аавтай минь ах дүү шиг сайхан ханилсан нэгэн. Жалбуу айлын аав [ɑili:ŋɑ:w] ламын булагт хонио усалж, манай хойгуур баруун урагш нь салхи сөрөн эгнүүлж орхиод манайд буулаа. (Ж.Цэрэндулам: “Мөнгөн баавартай эмээл”) (Цэрэндулам, 2013, х. 55). Буриадад “аав”-ыг [ɑw] гэхчилэн богиноор авиалдаг. Буриадад [ɑw] гэж дангаар хэрэглэгдэх үе биеийг төрүүлсэн эр хүйстэн буюу эцгээ заадаг. Хуучин баргад “аав”-

ыг утга хэрэглэлтийн талаар шинэ барга зүүн хошууны биеийг төрүүлсэн эр хүйстнийг заах утгатай адил боловч авиа дуудлага нь ондоо байж [awa:], [awa:di] гэж авиалдаг.

2. Монгол бичгийн хэлний “авга” гэх тохиролцох дуудлага нэрийг шинэ барга зүүн хошуунд [awaᠭ], шинэ барга хошуунд [awaᠭqa:] (авгахай), хуучин барга хошуунд [awga:] гэж авиалдаг. Энэ нь эрт цагт нэг үеийн цусан төрлийн эр хүйстнийг дуудахад хэрэглэгдэнэ.

3. Монгол бичгийн хэлний “хүргэн ах” гэх дуудлага нэрийг шинэ барга зүүн хошууны Шинэбулаг суманд [xurqa] (хурка), Өвөрбулаг суманд [xur□qa] (хурика) хэмээн авиалж, шинэ барга баруун хошууны Жавхлант суманд [xurqə] (хүркэ), шинэ барга баруун хошуунд [xurqa:] гэж авиалдаг. Хуучин баргад [xurax] (хурха) гэж, буриадад [xurǰaxai] (хурияхай) гэх мэтчилэн авиалдаг. Нийтдээ үе ялгалгүй насаар ах ургийн төрлийн эр хүйстнийг дуудахад хэрэглэдэг. Даруй өөрийн эгч, авга эгч, нагац эгчийн эр нөхрийг бүр дээрх дуудлага нэрээр дууддаг. Жишээ: Бөх хурка (хүргэн ах) маань бүдүүн өвснөөс бүдрээд уначихав уу? (Гармаагийн Шархүү “Дарийн үнэртэй тал) (Хөлөн буйр, 2014).

4. Монгол бичгийн хэлний “ээж” гэх дуудлага нэрийг шинэ барга зүүн хошууны Шинэбулаг суманд [mo:m], [aᠬi:a:] (ажияа) гэж хоёр янзаар дууддаг. Шинэ барга зүүн хошууны Өвөрбулаг суманд [mo:mo:], Хуучин барга хошуунд [mә:mә:] гэдэг. Шинэ барга баруун хошуунд [aᠬi:] (ажий), буриадад [iᠬi:] (ижий) гэж дууддаг. Эдгээр нь биеийг төрүүлсэн биеэс дээш нэг үеийн эм хүйстнийг заадгаараа адил утга хэрэглэлттэй байна. Жишээ нь: Барга ардын дуу “Алаг нүд минь мэлмэрнэ”-д

Ах дүү садан минь олон ч

Ажияад минь арай хүрэхгүй гэх мэт

5. Монгол бичгийн хэлний “нагац” гэх дуудлага нэрийг шинэ барга зүүн хошууны Шинэбулаг суманд [nagaᠰ], Өвөрбулаг суманд [nagaᠰ], буриадад [naga:], [nagaᠰ], хуучин барга хошуунд [nani:a], [nagsa:] гэж авиалдаг. Эдгээр үг нь эхийн үеийн цусан төрлийн эр хүйстнийг заадаг.

6. Монгол хэлний “дүү” гэх дуудлагыг шинэ баргууд ба буриадууд [du:], [du:dә:], хуучин баргад [du:dә:] гэж авиалдаг. Утга хэрэглэлтийн талаар адил үеийн насаар дүү эр хүйстнийг төрөл ялгалгүй дуудахад хэрэглэдэгээрээ адилхан байдаг.

7. Монгол бичгийн хэлний “хүргэн”-тэй тохиролцох дуудлага нэрийг шинэ ба хуучин баргачууд [xurᠭəᠨ], буриадчууд [xur□ᠭəᠨ]

(хүригэн) гэж авиалдаг. Ургийн төрлийн эр хүйстнийг үе ялгалгүй дуудахад хэрэглэдэг нь адилхан байна.

8. Монгол бичгийн хэлний “бэр” гэх дуудлага нэрийг шинэ ба хуучин баргууд [bәᠷ], буриадууд [bәᠷ□] гэж авиалдаг. Нас, үе ялгалгүй адилхан утгаар хэрэглэдэг. Хүү, бэр, ач бэр, зээ бэр зэргийг цөм бэр гэж дуудна.

9. Монгол бичгийн хэлний “өвөө” гэх дуудлагыг Өвөрбулаг суманд болон бусад шинэ барга зүүн хошууны баргууд [uwә:] гэж, шинэ барга баруун хошууны баргууд [əwᠭi] гэж дууддаг. Хуучин баргууд [uwә:], [xugfә:] гэдэг. Биеэс дээших хоёр үеийн цусан төрлийн эр хүйстнийг заадаг.

Хоёр. Авиа дуудлагыг адилавар ч утга хэрэглэлтээрээ зөрөөтэй дуудлага

1. [aᠬa:] гэх үгээр шинэ барга зүүн хошууны Өвөрбулаг сумын баргууд биеэс дээших нэг үеийн цусан төрлийн эр хүйстэн – биеийг төрүүлсэн эр хүйстнийг дуудахад хэрэглэдэг. Гэхдээ Шинэбулаг сумны баргууд [aᠬa:] гэх үгийг биеэс дээших нэг үеийн цусан төрлийн эм хүйстнийг дуудахад хэрэглэдэг.

2. [aw] гэх үг нь монгол бичгийн хэлтэй адил Шинэбулаг суманд төрсөн эцгээ заадаг бол Өвөрбулаг сумын баргууд [aw] гэх үгээр биеэс дээших хоёр үеийн цусан төрлийн эр хүйстэн – өвөө ааваа заадаг, “хөгшин” гэх тодотголтой нь өөрийн төрсөн эцгийн эцгийг зааж, “нагац” гэх тодотголтой нь эхийн эцгийг заадаг. Энэ Буриадуудын дуудлагатай адил. Хуучин баргад [aw]-ын өмнө “их” гэх тодотгол нэмж монгол бичгийн хэлний гэдэг утга адил эцгийн үеийн насаар ах цусан төрлийн эр хүйстнийг дуудахад хэрэглэдэг.

Мөн [iᠬi:] гэх дуудлага нь дангаараа хэрэглэгдэхдээ баргуудын дунд аавын эх, эмэг эхийн дуудлага нэр болж хэрэглэгдэнэ. Гэвч барга ардын дуунд ижий аав хоёр гэж хэрэглэх байдал тун олон байдаг. Үүнээс үзэхэд ижий гэх үгийг баргууд, биеийг төрүүлсэн эм хүйстнийг хүндэтгэн дуудахад хэрэглэдэг. Харин Буриадууд өөрийн төрсөн эхээ дуудахад хэрэглэдэг. Хуучин баргуудын дунд хадам эхээ ижий гэж дуудах байдал байдаг. Жишээ нь: “Өнөө цагийн хүүхэнчүүл хэлсэн нь байна гэсэн шиг батлагаа үгүйгээр хадамындаа ижий [idzi:] нь болмоор суучихдаг нь одоо л моод шоод болж байгаа биш үү” (Чулуунбаатар, 2008, х.98). “Аав ижий хоёр хөвгүүн хүлээдэг байв. Тэгж манай ижий манай нагац аавын дүүгийнхээс арваад хүрч явсан Базар гэдэг хөвгүүнийг үр болгон авсан юм” (Даримаа Түмэнов, х.105).

3.[axa i] Шинэ барга зүүн хошууны Шинэбулаг суманд ах, авга болон нагацынхаа эхнэрийг ахай гэж дууддаг. Өвөрбулаг сум болон шинэ барга баруун хошуунд ахайн оронд голдуу бэргэн гэх дуудлагыг хэрэглэдэг. Харин Буриадад [axa i] гэх энэ дуудлага нь ах ба авгын дуудлага болж хэрэглэгджээ. Жишээ нь: Базар ах булт (бүгдүүл буюу олон гэсэн санаатай-эшлэгч)-ын ах гэсэн хойно бултад “ахай, ахай” гэхүүлэхээс ондоо нэр мэддэггүйсэн. (“Ахын тухай үг”). Монгол бичгийн хэлний “ах” гэх дуудлага нэрийг шинэ барга зүүн хошууны Шинэбулаг сум ба шинэ барга хошуунд [ax] гэж, шинэ барга зүүн хошууны Өвөрбулаг суманд [aga:] (агаа) гэж авиалдаг. Хуучин барга хошуунд [axa:], [axa:di] гэж дууддаг. Шинэ ба хуучин баргууд нь голдуу үеийн насаар ах цусан төрлийн эр хүйстнийг дуудахад хэрэглэдэг. Буриадад [axa i] гэж дууддаг. Буриадчууд ахай гэх үгийг нас, үе ялгалгүй хэрэглэдэг онцлогтой. Насаар ах хүн, авга үетэй хүн, хүргэн ах болох хүмүүсийг бүгд “ахай” гэж дууддаг.

4.[awga i] баргад дунд гэр бүл болсон эмэгтэй хүнийг авгай гэдэг бөгөөд өөрийн эхнэр буюу бусад хүний эхнэрийн дуудлагаар ч хэрэглэгддэг. Харин буриадад авга ба нагацынхаа эхнэр болон ахынхаа эхнэр ба хүний эхнэрийг авгай, бэргэн хүнээ буриадад ургийн төрлийн эм хүйстнийг нас, жил, үе ялгалгүй ингэж дууддаг байна. Жишээ нь, уул нь ээжийг чинь оёдолд уран, ажилд дэмтэй болохоор нь аав нь сая авгай [awga i] болгон авсан юм даа. (“Саарал морь”)

5.Монгол бичгийн хэлний “эгч” гэх дуудлагыг шинэ барга зүүн хошууны Шинэбулаг суманд [ʧa:ʧa:] (жажа) гэж дуудах бөгөөд хөгшин залуу, хүүхэд гэж үе ялгахгүй хэрэглэдэг. Шинэ барга хошууны Өвөрбулаг суманд [ʧε:ʧε:] (жие жие) гэж авиалж, зөвхөн адил үеийн насаар ах эм хүйстнийг дуудахад хэрэглэгдэх онцлогтой. Хуучин барга хошуунд [ʧə:ʧə:] (жеже) гэж авиалах бөгөөд бас Өвөрбулаг сумныхтай адил хэрэглэгдэх онцлогтой. Жишээ нь, 2013 оны нэгэн өдөр, манай ач бэр [aʃ bəʃ] захидлын хайрцгаас сонин сэтгүүлийг минь авчирч өгөхдөө: “Жажа [ʧa:ʧa:] аа, таны бичиг дотор нэг товдонтой бичиг ирсэн байна. Ямар бичиг бол доо” гэхэд нь би: “задлаад үзээч дээ” гэсэн юм (Цэрэндулам, 2013, х.52).

Гурав. Үгсийн сангийн зөрөө

Төрөл садны дуудлага нь монгол хэлний үгсийн сангийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох юм. Барга, буриад аялгууны өөрийн онцлогтой үгсийн дотор, авиа дуудлагын талаар ялгаа зөрөөтэй үг гол байрыг эзэлдэг. Тус тусынх нь аялгуунд үүсэж

бүтсэн үг, утга зөрөөтэй үг, өвөрмөц зээллэг үг гэх мэт өвөрмөц онцлогтой үгс бас тодорхой хэмжээгээр байдаг. Зээллэг үгсийн талаар барга, буриад аялгуунд хятад зээллэг үгс байх ба орос, манж цаашилбал, дагуур хэлнээс зээлсэн үгс ч хэрэглэгдсээр байгаа нь хэл, соёлгүй барга ба буриадчуудын түүх, амьдарч буй газар орон мөн бусад үндэстэнтэй соёлын харилцаатай нь нягт холбоотой юм (Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэлийн удиртгал”, 2005, х.455).

1.Барга буриадчуудын үндсэн дуудлага нэр дээр тодотгол нэмж үүсмэл дуудлага нэр үүсгэсэн байдал олон бий. Жишээ, ахай гэх үгэнд “шинэ, гоё” гэх гэмдэг үгээр тодотгосноор шинхай, гоёхой гэж товчлон дууддаг. Мөн бүдүүн жаажая, хөгшин жаажая, их аав, бүдүүн мөөмөө, жаахан бэргэн, жаахан авга, бүдүүн авга, хөгшин аав, хөгшин ижий, шинэ агажи, ах мемен, агажи мемен гэх мэт ч үгээр авгайлж дууддаг.

2. Өвөрмөц нийлмэл үгсийг дан дуудлага нэр болгосон үзэгдэл зөндөө тохиолдоно. Жишээлбэл, хуучин баргад хүргэн ахыг хураха шинэ барга зүүн хошуунд хүркэ, хурка, хурика гэж олон янзаар дууддаг болжээ. Өвөрбулагт жаахан ахыг нийлүүлээд жааханхай [ʧa:xaŋqai] гэж дууддаг ба авга, ажияа гэх хоёр үг нийлж авааж [awgaʧa:] хуучин баргын хөгшин аавыг [xugʃə:] (хөгше) болгосон жишээ байдаг.

3.Зээллэг үгс. Хуучин баргачуудын дуудлага нэрд манж түнгүс, дагур гаралтай үг нэлээд байдгийн жишээ нь “хэрэв Пүмэн эмбэ [əmbə:]”-ээ эргэж ирдэг л юм бол нагац та эвийг нь үзэж болгоно биз” (Цолмон сэтгүүл, 2008). (Урансайхан. Дэлгэр “Тооноор туссан хунгийн цуваа”

- “Нагацын үхүй [nagsaŋxui] тэнхээ гайгүй? гэх мэтээр их л ялгуйхан байгааг хараад пейсүй хөгшин өөрийн таамаглалаа бүрмөсөн зөвтгөөд: хөөрхий, гайгүй, гайгүй. Ингэж л эднүүстэйгээ л зууралдаад явж байна даа! Гэж хоёр үеийн бэрдээ харахдаа нүдээрээ “зочдоо, суулгачих” гэсэн шиг дохилоо”. (Тооноор туссан хунгийн цуваа)

- Намжилмаагийн үгмээ [uɣimə:] нь түүнээ онгойлгоод бяцхан алчуур гарган биднийг хөлсөө арч гэж өгсөн юм гээд хармаанаасаа бяцхан гар алчуур гаргаж эргүүлэн үзүүлнэ. Үгмэ гэдэг нь хуучин баргад авга бэргэнийг заадаг. (“Тооноор туссан хунгийн цуваа”)

Дээрх хэдэн жишээнд “эмбээ, үхүй, үгмээ” зэрэг дуудлага нь харь гаралтай үг болно. Харь гаралтай дуудлага нь хуучин баргад бусад хоёр шинэ барга хошуу болон буриадад цөөн тохиолдоно.

4.Өвөрмөц дуудлагад хуучин баргууд отгон авгаа дуудахдаа хүндэтгэн отгон, отооди [ətə:di]

гэж дууддаг. Жишээ, (1) Олуулаа бөөгнөрөн очоод Эрэлхэг цогийг хүрээлэн: Отхоо [ɔtχə:] сайн яваад ирэв үү? Очсон зорилгодоо хүрлээ юу? гэж ам булаалдан мэндчилнэ. ("Тооноор туссан хунгийн цуваа") (2) Урьдын ураг цагт, урин дулаан байхад, өргөн уужим дайдад, өвөг хамган [χamɣaŋ] хоёр суусан гэнэ. ("Буриадын түүх бичгүүд", Улаан-Үд, 1998 он)

Монгол бичгийн хэлэнд өвгөн хөгшин буюу өвгөн, эмгэн гэж хэлдэг бол буриадад өвөг хамган гэж хэлдэгийг дээрх жишээнээс ойлгож болно. Буриадууд охид эмэгтэйчүүдийг хүмүүсийг басган гэж дууддаг. Харин хуучин баргууд охин [uxiŋ] гэж дууддаг.

5. Аман аялгуунд бүтсэн үг. Хуучин баргууд ависан ажинг аюун, аюулан гэж бас бажыг база, базалан гэдэг. Харин шинэ барга зүүн хошуунд энэ үгийг төдийлөн хэрэглэхгүй, нэг айлын бэрүүд гэж хялбарчилсан байдлаар дууддаг байна.

Дөрөв. Хэрэглээний орчны зөрөө

1. Авгай ахай [awɣaɪ aχaɪ]-баргад хуримласан эр, эм хоёрыг нэрлэсэн дуудлага. Жишээ нь, (1) манай хүү бэр хоёр гэж сонин зантай. Үнэндээ үр хүүхэдтэй айл гэрийн авгай ахайн хооронд цөөн ч болог халуун дулаан яриа байдаг биз. ("Дарийн үнэртэй тал"), (2) Гучин хэдэн жилийн өмнө цэргээс халагдсан залуу, сэхээтэн залуу нэртэй, ирээдүйд айлын авгай ахай хоёр бололцсон бид хоёр мөн л энэ замаар Эрдэнэтөлгой тийш давхиулж байсан маань энүүхний үлгэр биш болжээ ("Хасангуа: "Эрдэнэтөлгойдоо эргэж очсон нь"), (Хөлөн буйр сэтгүүл, 2014, х.59)

2. Гоёхой [ɣoɪχoɪ] гоё ахай. Ахын эхнэрийн дуудлага нэр. Шинэ барга зүүн хошууны Шинэбулаг суманд ахынхаа шинэ бэрийг ингэж дууддаг. Шинухай [ʃɯŋχaɪ] шинэ ахай гэх нь мөн ахын эхнэрийн дуудлага. Шинэ барга зүүн хошууны Өвөрбулаг суманд ахын шинэ бэрийг ингэж дууддаг. Энэ нь бас зөвхөн Өвөрбулагт байдаг онцгой дуудлага мөн. Шинэ ааж [ʃɯna:ʧi:] - хуучин багад ахынхаа шинэ хуримласан эхнэрийг дуудах дуудлага.

3. Авгахай [awɑɣɑɑi]-Шинэ барга хошууны Өвөрбулаг сум ба шинэ барга баруун хошуунд аавынхаа ах дүү буюу авга нарыг дуудах дуудлага мөн.

4. Хүр, хүргэн-хуучин барга ба Өвөрбулагт хадам дүү гэх үгийг хүр дүү гэх байдлаар илүү хэрэглэдэг. Жишээ: Өвөрбулагын Сахирад мэргэн Цэвэл нь миний өвгийн дүү хүргэн [du: χurɣəŋ] юм. Манай садан төрлийн доор үеийнхэн бүгд мэргэн хүр ах [χur aχ] гэж хүндэтгэн дууддаг сан (Цэрэндулам, 2013). (Ж.Цэрэндулам: "Анд

мордсон нэг өдөр") Энэхүү жишээнээс нийт монгол бичгийн хэлэнд дуудагддаг "хадам ах, хадам дүү" гэх дуудлагыг Өвөрбулагчууд "хүр ах, хүр дүү" гэж дууддаг болохыг садны дуудлагын материалыг тус жишээгээр нотолж болно.

Тав. Шилжсэн утгаар хэрэглэгдэх байдал

1. [ba:wɪ:] - гэх дуудлагаар шинэ барга зүүн хошууны Өвөрбулагаас бусад сумдад өөрийн төрсөн ахаа өхөөрдөж дууддаг ба өөрөөс нь ах хүнд мөн хэрэглэгддэг. [ba:wɑi]-г Байгалиас хойших Буриадууд аавыгаа баавай, Байгалаас өмнө буриадууд авгаа баавай гэдэг. Шинэхэн Буриадад авгай аваагүй аавын үеийн эр хүйстнийг баавай гэж дууддаг. Буриад ардын дуунд:

Алтай хатайн хажуухан
Агтайн дөрвөрхэн гараана л
Ах бавайн [ba:wɑiŋ] тэргэнхэн
Нааданай дөрвөрхэн гараана л (Оюун түлхүүр", 1982).

Дээрх жишээ нь буриад ардын дууны шүлэг дэх баавай нь ах, авга үетэй хүнээ хэлсэн байна. Бас буриадын нэрт шүлэгч Н.Сэмжидийн үг, дуучин Цэцэгмаагийн аялгуу болох "Буриад" гэх дуунд "Баавай саяны эхэн буриад" гэх нэг бадаг үгэнд Саян гэж сарьдаг уул нурууг заадаг бол, "баавай саян" гэгч нь аав шүтээн уул гэх хүндэтгэлийн дуудлага болохыг мэдэж болно.

2. Нагацхай [naɣtχaɪ]. Монгол бичгийн хэлний "нагац"-ыг баргуудын дотор зарим нь нагацаа нагацхай гэж, зарим нь нагац бэргэнээ нагацхай гэх нь бий. Айл болгоны дуудлагын заншил ондоо ондоо байдаг. Жишээ нь, (1) бидний очсоны хоёр дахь өглөө, цайгаа ууж байхад Сугар ах "Ажаа [ɑʧɑ:] аа, би өнөөдөр нэг мордох уу? Эсхүл та мордоно уу? Нагац, нагац ахай [naɣtχaɪ] ирээд хоёр хоночихлоо. Олон ирэх ч биш дээ, шөл уулгах юм уу гэсэн юм аа" гэж байна. ("Анд мордсон нэг өдөр"). (2) Нагацхай (нагац) намайг "Ааваа тосож авчир" гэсэн. ("Дарийн үнэртэй тал"). Дээрх хоёр жишээнд зохиогч Ж.Цэрэндулам бол Өвөрбулаг нутагтай хүн байж, бас анд мордох үйл хэргийг асуусан болохоор жишээ дэх "ажаа" нь эрэгтэй хүнийг заасан мөртөө өөрийн эцгээ заалаа гэж ойлгож болно. Тус жишээнд бас нагац, нагацхай гэж зэрэгцүүлж ярьснаас "нагацхай" нь нагац бэргэнээ заажээ. Хоёрдугаар жишээнд зохиогч Гармаагийн Шархүү бол хуучин барга хошууны Баянхүрээ балгасны хүн мөртөө уул зохиолд нагацхайн доор хаалтанд нагац гэж тайлбар хадсан нь хуучин баргадууд нагацхай гэж нагацаа хэлдэг гэснийг ойлгож болно.

3. Ахай [ɑχaɪ] - одоогийн хэрэглэгдэж байгаа утга нь шинэ барга зүүн хошууны Шинэбулагт

бэргэн гэх утгаар олонх байдалд хэрэглэгдэнэ. Гэвч дээр үеийн хүмүүс дотор Жавхлант сум, уулын Хөвөөт шард эгчийгээ ахай гэх үзэгдэл байдаг ба эрэгтэй хүнийг ахай гэж авгайлж дууддаг үзэгдэл бас байдаг гэснийг хөгшчүүлийн ярианаас сонсож мэдлээ. (1) Энэ тухай барга ардын дуу “Дэмтэй л явахыг хичээгээрэй” гэх дуунд:

“Дээд л ахайг нь асуувал дэгжин ч гэмээр залуухан

Дэндүү л дурласан бүл дэмтэй л явахыг хичээгээрэй

Авгай л нөхрийг нь харвал аятай ч гэмээр залуухан

Аргадаж дурласан бүл аргадаж явахыг хичээгээрэй”

Дээрх дуун дахь “ахай” нь даруй эгч гэх утгаар хэрэглэгдэж байгааг барга ардын дууны эмхэтгэлийн хятад харьцуулалд “姐姐” гэх орчуулгаар нотолж болох юм. (2) Жишээ нь, Наяад онд зээ Бямба “ахай [ɑxɑi], эмээлээ над өгчих” гээд салахгүй болов. (“Мөнгөн баавартай эмээл”)

4. Авгай [ɑwɑɑi] хуримласан бүсгүй, гэргий, эхнэр, зөвхөн хүндэтгэхэд хэрэглэх биш, энгийн үеийн дуудлагад хэрэглэнэ, ~ буулгах; ~ болох гэж байгаа хүүхэн; улаан дээлтэй л бол манай ~ (хошин үг). Гэтэл авгай гэвэл буриадад ах, авга, нагац нарын эхнэрүүдийг дуудахад бүр хэрэглэдэг, Шинэ булагийнхнаар бэргэний дуудлагатай ойролцоо утга нь авгай болно. Энэ тухай Хайлар нэгдүгээр дунд сургуульд барга буриад, энги, урчан зэрэг цөөн тоот үндэстэн ястны хүүхдүүд суралцдаг. Тэр үед буриад хүүхдүүд өдөр бүр “аавжа минь ирлээ” гэхгүй бол “авгай минь ирлээ” гэдгийг сонсох болгон барга хүүхдүүд их л гайхаж “сурагч мөртлөө авгайтай болсон юм уу даа” гэж гайхдаг байсан.

5. Аажий [ɑ:ʃi:] нь дангаараа хэрэглэгдэх нь хуучин баргад эгч гэх утгатай дүйж байдаг. Шинэ гэх тодотгол нэмэгдэх үед бэргэн гэх утгыг илэрхийлнэ. Зарим үед дангаар хэрэглэгдэх үед бэргэн ба хадам эхийн дуудлага болж хэрэглэгддэгийг ардын дуунаас ойлгож болно. Жишээ: Барга ардын дуу “Өвөөлжин шувууны дэгдээхий”-д “Өвөөлж шувууны дэгдээхий өвлийн эриндээ ташигмдхай, үзээч үгүй аажийгаа өнгөрөө ч дуулахаа гайхана би”

Хятад харьцуулалд нь аажий гэх үгийг “嫂子” гэж хадаж буй. Бас жишээлбэл, барга ардын дуу “Тавилан”-д:

Амбан бүдүүн шарууд

Аралаа чирэх л заяатай

Аажийн хотонд заясан

Авгай миний л тавилан аа

Хятад харьцуулалд “婆母” гэж орчуулжээ. Үүнээс үзвэл шинэ бараг баруун хошуунд төрсөн эхээ “ажиа” гэж дууддагтай тохирч байна. Жишээлбэл, Барга ардын “Алаг нүдэн минь мэлмэрнэ” гэх дуунд:

Эгч нар садан олон ч

Аажий [ɑ:ʃi:] -д минь арай хүрэхгүй

Зургаа. Үе зэргийн дээд доодын ялгалын балархайшил

“Монголчууд дээш есөн үе, доош есөн үе, биеийн адил үетэйгээ арван есөн үеэ дуудаж чадна” гэдэг боловч, баргууд үеийг нарийн ялгагдаггүй (Намсрай, 1987, х.23). Өвөөгөөс дээш үе болон өвөөгийн ах дүүг бүгдийг өвөөтэйгээ адилхан дууддаг. Жишээлбэл, элэнц өвөг, хуланц өвөг, элэн өвөг, хулан өвөг, холбоо өвөг, өндөр өвөг, бэлдэн өвөг зэрэг эцгээс дээших долоон үеийг нэрлэсэн тусгай дуудлага байхгүй, өвөгтэйгээ адилаар дууддаг. Доош бол өөрийн хүү, ач, зээ, гуч, жич хүртэл нэрлэдэг. “Хажуугийн (хөндлөн) хэлхээгээ ялгах талаар, монгол бичгийн хэлэнд төрсөн, үеэлд, хаялд, үе, хаяа, үеэнчир, хаянчир, төрлийн гэх мэтээр найман хэлхээгээ дуудаж чаддаг” бол, баргууд эдгээр дуудлага үгийг бараг хэрэглэхгүй (Намсрай, 1987, х. 23). Эцгийн төрөлд хэрэглэдэг авга ачаалан [ɑwɑɑ̃ ɑʃɑ: |ɑŋ] (авга, ач) гэх үг яригддаг. Буриадууд үеэ тоолно гэж ярьдаг. Олонх буриадууд долоон үеэ нэрлэж чадна. Гэхдээ тэд “хэний хэний хэн” гэж нэрийг нь цээжилж, нэрээр нь нэрийдэн дууддаг заншилтайгаас биш, тусгай дуудлага үгийг хэрэглэдэггүй. Буриадууд “үеэл, ависан ажин, бөл, баз” зэрэг дуудлагыг баргуудаас илүү хэрэглэдэг болохыг хээрийн судалгаагаар мэдэж болно. Баргууд харин “бөлөөлөн, баз, авга, ачаалан”-ыг харьцангуй олон хэрэглэдэг.

Долоо. Хүйс солбицон хэрэглэгдэх дуудлага нэр

Нэгд, хөгшин [xugʃiŋ] Шинэбулагт эм хүйсийг илтгэнэ. Өвөрбулаг сум ба Буриадад төрөл садны дуудлага нь хүйсийн ялгалгүй хэрэглэгдэнэ. Шинэбулагт аавын том ах ба хамгийн их авга эгчийн эрэгтэйг “өвөг авга, өвөг хурка”, аавын хамгийн том эгч ба эхийн эгчийг “хөгшин жаажаяа” гэж дууддаг. Шинэбулагт эрэгтэй, эмэгтэй хүнд өвгөн, хөгшин гэх үгийг ялган хэрэглэдгээс “өвгөн” нь эр хүйсийг илтгэж “хөгшин” нь эм хүйсийг илтгэдэг болно. Өвөрбулаг ба буриад зонхон “хөгшин аав, хөгшин ижий” гэдгийг биеэс дээших нэг үеийн эр хүйстэн ба эм хүйстэнд хэрэглэхээс гадна Өвөрбулагт “хөгшин хурика” гэдгийг эрэгтэй хүнд хэрэглэж даруй хүйсийн ялгаагүй хэрэглэдэг байна. Хуучин баргууд биеэс

дээш хоёр үеийн эр хүйстэн-болох өвөө ааваа [uwə:] гэж дуудахаас гадна [xugʃə:] гэж дууддаг нь хөгшин ааваас улирч ирсэн хүндэтгэл дуудлага байж мэднэ. Үүнээс үзвэл хөгшин нь бас эр хүйс, эм хүйсийг илтгэдэг байна.

Хоёрт, ахай [ɑxɑi] баргадад эм хүйсийг илтгэж, буриадад эр хүйсийг илтгэдэг. Шинэ барга зүүн хошуунд Шинэбулаг сумны баргадууд голдуу ахын эхнэр, авгын эхнэр, нагацын эхнэрүүдийг дууддаг. Буриад бол эсрэгээр ах, авга, нагацаа "ахай" гэж дууддаг.

Гуравт, анжиа - анжиа гэх үг нь Өвөрбулаг суманд эцгийн эгч, охин дүүг нэрлэх нэршил юм. Гэвч Гүл цагаан хошууны Шинэбулаг суманд Бя.Цэвэгийн "Андын журам" гэх өгүүллэгт нэг айлын өвгөн хөгшин хоёрын тэжээлгэсэн хүү Балбар нь "Энэ хорвоод намайг наашаа гэж өөд татсан энэрэлтэн" анжиа аниа хоёр минь гэж дууддаг. Үүнд анжиа бол дээр үеийн эр хүйстний нэршил юм. Хээрийн судалгааны баримтад дурдсанаар шинэ барга зүүн хошууны Ганжуур суманд нагац бэргэнээ анжиа гэж дууддаг. *Анжиа нь ная хүрч насан өөд болсон* гэдэг. Бас жишээлбэл: "Агсам саарал" гэх барга ардын дуунд:

Агсам агсам саарал чинь аймгийн найртаа тоожуухан

Анжиагийн лам аль ач л бэрдээ тоожуухан

Дөрөвт, нагацхай-шинэ барга зүүн хошуунд нагац бэргэнээ нагацхай гэдэг. Хуучин барга хошууны Гармаагийн Шархүүгийн "Дарийн үнэртэй тал" гэх өгүүллэг найруулалд нагацхай гэж нагацаа дууддаг. Жишээ: *Нагацхай (нагац) намайг "ааваа тосож авчир" гэсэн.*

2. Харилцааны нэвтрэлцэл дэх дуудлагын түгжрэлийг шулуутгах арга сэтгэц

Нэг. Сургуулийн сурган хүмүүжилд түшиглэх

Барга, буриадууд өөр өөрийн хэл аялгуутай байдаг. Тэрчлэн төрөл садны нэр, нэршил нь өөр өөр байна. Баргууд нэг хүнийг үе, нас, хүйс зэргээр ялгаж нэр хүндэтгэлийн өнгөөр дууддаг байна. Баргууд харилцааны явцад хэн нэгэн хүнийг дуудахдаа энэ хүнийг өөртэйгээ үе зэрэг, нас жил, цусан төрөл ба овог төрлийн аль нь болохыг бодон байж дууддаг. Харин Монгол улсын орчин үеийн иргэд хуримласан хуримлаагүй хөгшин залуу ялгаагүй ах, эгч гэж дуудах, буриадынх шиг "ахай, аавж" гэх хоёр дуудлагаар дуудах эсвэл шууд нэрээр нь дууддаггүй юм. Иймээс сургуулийн боловсролоор дамжуулан барга буриадуудын явцад бие биенээ хүндэтгэн дуудлагын соёлд

суралцуулах нь туйлын чухал юм. Харилцааны соёлд суралцах нь хамгийн чухал асуудал билээ. Онцгойлон хэл авианы сонсох дадлага боловсролыг сайн эзэмшсэн байх хэрэгтэй. Учир нь тэд нэг л дуудлагыг хэдэн янзаар авиалах зэрэг нарийн зүйлс олон байдаг.

Хоёр. Соёл урлагийн үйл ажиллагааг өргөжүүлэх асуудалд

Барга түмний урлаг соёлын "Баргажин" анхдугаар наадам-Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал сумын иргэдийн санал хүсэлтээр Дорнод аймгийн засаг даргын 2007 оны 6-р сарын 28-ны өдрийн 229 тоот захирамжаар барга ястны урлаг соёлын "Баргажин" анхдугаар наадмыг зохион байгуулахаар шийдвэрлэснийг "Барга судлалын холбоо" Улаанбаатар, Чойбалсан хот дахь Хөлөнбуйр, Гурванзагал сумын нутгийн зөвлөл, мөн сумын иргэд хүндэтгэлтэйгээр хүлээн авч, анхдугаар наадам Монгол, Оросын холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс гэсэн гурван улсын иргэдийг хамран Дорнод аймгийн Чойбалсан хот, Гурванзагал, Хөлөнбуйр сумыг дамжин 2007 оны 8-р сарын 20-оос 24-ний хооронд 5 өдөр үргэлжилжээ. Чойбалсан хотод "Барга түүх, соёл судлал" эрдэм шинжилгээний бага хурал, Гурванзагал суманд Манлай баатар Дамдинсүрэнгийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслол, Хөлөнбуйр суманд урлаг соёлын үндсэн арга хэмжээнүүд зохион байгуулагдав. Баргын урлаг соёлын "Баргажин" анхдугаар наадам нь хөрш зэргэлдээ ахан дүүс, садан төрлийн холбоотой гурван улсын ард иргэдийн төлөөлөгч оролцов. Баргын ураг төрөл, хал омогийнхон өөрсдийн уриа, онцлог шинжийг харуулсан бэлгэ тэмдэг бүхий туг далбааг өргөцгөөж, үндэсний бөхийн барилдаан, шатрын тэмцээн, бүжгийн тоглолт зэрэг үндэсний урлагийн тоглолтыг зохион байгуулж, гоо сайхан, эв нэгдэл, амар амгалан, аз жаргалын бэлгэдэл болсон хун шувуун дүрст баргажин наадмын тугийг мандуулан наадсан байдаг (Баатуд Равдан, 2013).

Наадмын үеэр нутгийн ард иргэдэд хадгалагдаж байгаа болон Дорнод аймгийн музейд өвлөгдөж ирсэн барга түмний түүх, соёлын өв уламжлалт эд өлгийн зүйлсийн үзэсгэлэн, мөн барга овгийн хонины үзэсгэлэн худалдаа зэрэг өвөрмөц олон үйл явдлыг анх удаа санаачлан зохион байгуулсанаараа онцлог байлаа. Хөлөнбуйр суманд барга ястны "Баргажин" анхдугаар наадам 2007 онд болж Оросын Холбооны Улс Өвөр монголын өөртөө засах орны баргууд оролцсон, анхны уулзалт амжилтай болж, оролцсон хүмүүс баяр талархлаа илэрхийлжээ. Наадамд морь уралдаж, бөх

барилдаж, “Барга ястны түнх харваа”-г харвав. Мөн 4 жилийн дараа 2011 онд Гурванзагал суманд “Баргажин” хоёрдугаар наадмыг зохион байгууллаа. “Монголд байгаа барга ястнууд, Оросын Холбооны Улсын болон Өвөр монголын өөртөө засах орны өвөр монголчууд энэ наадамд оролцож “Баргажин” гуравдугаар наадмыг Оросын Холбооны Улсын баргажин районд 2015 онд хийхээр тохиролцсон” бөгөөд тогтоол ёсоор 2015 оны 6 сард Оросын буриадын Улаан-Үд хотод амжилттай явагджээ (Баатуд Равдан, 2010). Харин барга буриадын хэл соёлын уламжлалыг бүрэн бүтэн хадгалж байгаа Дундад улсын Өвөр монголын Хөлөн буйр хотод “Баргажин” ба “Алтаргана” наадмыг тогтсон хугацаанд зохион байгуулах нь Барга Буриадчуудын соёлын харилцааны нэг хэлбэр болно.

Гурав. Хэвлэл мэдээлэл дэх нийтлэл нэвтрүүлгийн тухайд

Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн мэдээлэл авах хамгийн түгээмэл арга зам болоод байна. Жишээлбэл, Хэвлэл мэдээлэл дэх барга, буриад соёлын нэвтрүүлгээс дурдвал, “Балжин хатны домог” гэх дөрвөн бүлэгт жүжиг, кирил монгол, орос, англи гурван үсгээр харгуулж хошин зургаар илтгэсэн буриад зүйл үгэнд хятад үсгээр тайлбарласан, “Буриадаараа ярья” гэх кино, “Буриад монгол юүдэн малгай” гэх зурагт мэдээлэл, буриад эмэгтэйчүүдийн уг ёсоо эрхэмлэж, буриад эмэгтэйчүүдэд байвал зохих чанар уламжлалаа баримтлахыг уриалсан - “Шинэ эриний буриад эмэгтэйчүүдийн даатгал” гэх кино, “Ёхор”, “Барга буриадын эх үүсэл” зэрэг телевиз програмууд нь бидэнд буриад хэл аялгууны хамгийн сайн гарын авлага болж байна. Шинэ барга зүүн хошууны утга, урлагийн холбооноос эрхлэх “Амгалан цэцэг” сэтгүүл, шинэ барга баруун хошууны “Хэрлэн” сэтгүүл, “Хөлөн буйр сэтгүүл” нь улсын барга судлалын үнэт өв болж, гадаадад “Барга судлал”, “Буриад судлал” сэтгүүл хэвлэгдэж байна. Хөлөн буйр хотын барга судалгааны нийгэмлэг нь гурван барга хошуунд үйл ажиллагаагаа өргөжүүлж, 2011 онд Хөлөн буйрын буриад монгол судалгааны нийгэмлэгийг байгуулснаар судалгааны эхлүүлж, удам угсаа түүх соёлоо судлан уламжлах, барга судалгаатай холбогдох ажлын мэдээ мэдээллийг өргөжүүлж байна.

ДҮГНЭЛТ

Соёл нь уламжлагдаж өвлөгддөг бөгөөд хувьсан өөрчлөгдөж байдаг. Иймд ямар нэгэн угсаатны өвөрмөц соёлын бүрэлдэх, хадгалагдах, уламжлагдах нь өөр өөрийн гэсэн өнгө төрхтэй хэмээн үзжээ.

Баргажин анхдугаар наадмын хүрээнд болсон эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхэтгэж “Баргажин-2007” ном хэвлэн гаргав. “Бидний хэдэн нөхөд барга угсаатны уг удам, өв соёл, хэл, зан заншил нь олон зууны нүүдлийн амьдрал түүхийн явцад шалтгаалан бүдгэрэн буйг хэлэлцээд өвөг дээдсийн өв соёлыг үр хойчдоо үлдээн дамжуулах гэсэн нэгэн үзүүрт сэтгэлийг барин Дорнод аймгийн “Баргын өв” төрийн бус байгууллагыг үүсгэсэн билээ. Энэ нь эрхэм агаад нүсэр зорилгыг үйл хэрэг болгох нэгэн арга нь нийтлэл, уран сайхны сэтгүүл гарган түгээх явдал гэж тогтоогоод нэлээдгүй хугацаанд цөөнгүй хүний цаг завьг барин байж сэтгүүлийн материал цуглуулан ийнхүү эмхэтгэнэ” гэж баргажин сэтгүүлийнхэн барга соёлын төлөө чармайн ажиллах урам зоригоо илтгэсэн байдаг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Хөлөн буйрын барга судлалын нийгэмлэг. (2013). *Барга судлалын өгүүлэлийн түүвэр*. Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо
- Хуасай.Цогт. (2011). Шинэхэн буриад монголчууд. Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо
- Өлзий, Ж. (2012). Барга монголын товч түүх. Өвөр монголын товч түүх. Өвөр монголын хэвлэлийн бүлэглэл, Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Батуева, С.Д., Балжинямаева, Ц.Ц. (2007). Буриад зоны урьдын суудал байдал. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо
- Боржигон Ванжилв. (2010). “Хөх зул” монгол уламжлалт амьдралын толь”. Өвөр монголын хэвлэлийн бүлэглэл. Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо
- Намсрай. (1992). “Монгол дагур хятад төрөл садны дуудлагын толь”. Хөх хот: Өвөр монголын ардын хэвлэлийн хороо

1. 胡明扬:《书面成语和礼仪用语》, 外语教学与研究出版社, 北京, 2011年。